

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,
БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО ХООРОНДЫН
“НЭГ ЖУУЛЧИН - НЭГ ХОНЬ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2023 оны 11 дүгээр сарын
25-ны өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам /цаашид “Яам” гэх/, нөгөө талаас Булган аймгийн Засаг даргын тамгын газар /цаашид “Аймаг”/, “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “Холбоо”, хамтад нь “Талууд” гэх/ нар Аялал жуулчлалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалт, 26 дахь зүйлийн 26.2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн, энэхүү Хамтран ажиллах санамж бичгийг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024, 2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын жуулчдыг тоо нэмэгдүүлэх зорилтот ажлын хүрээнд талууд хамтран ажиллах, санал солилцох, “Нэг жуулчин - Нэг хонь” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Санамж бичгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнд зарцуулагдах зардлыг Булган Аймгийн Засаг Даргын Тамгын Газар өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

ХОЁР. ЯАМНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

2.1. Аймгаас явуулж буй аялал жуулчлалын үйл ажиллагааг дэмжиж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

2.2. Аймаг руу чиглэсэн гадаад, дотоодын аялал жуулчлалын сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, тодорхой хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.3. Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирсэн жуулчид Булган аймагт зочлох, тэдний сонирхлыг татах зорилгоор тусгай хөтөлбөр гаргахад Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран ажиллана.

2.4. Аймагтай хамтран, “1 жуулчин - 1 хонь” хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, Бүгд Найрамдах Солонгос Улсад энэ талаар мэдээлэл түгээх, сурталчилгаа явуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.5. Хууль, тогтоомжийн хэрэгжилт, санамж бичгийн нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

ГУРАВ. АЙМГИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1. Аймагт ирсэн жуулчдад Монгол орны уламжлалт мал аж ахуй, нүүдэлчин ахуйг сурталчлах зорилгоор тус аймгийн малчин өрхүүдэд зочлуулах, аж амьдрал, ахуйтай танилцуулах, найрсаг, нөхөрсөг харилцааг бий болох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2. Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирсэн жуулчдад орон нутгийн малчин өрхийн маллаж буй хоттой хониноос тус бүр 1 хонь зүсэлж өгч, тухайн малчнаар хариуцан маллуулах ажлыг зохион байгуулна.

3.3.Санамж бичгийн 3.1, 3.2-т заасан ажлыг сум, багийн хэмжээнд нэгдсэн удирдлагаар ханган, зохион байгуулалтыг хариуцаж ажиллана.

3.4. Бүгд Найрамдах Солонгос Улсаас ирсэн жуулчид Булган аймагт зочлох, тэдний сонирхлыг татах зорилгоор тусгай хөтөлбөр гаргахад Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран ажиллана.

3.5.Хууль, тогтоомжийн хэрэгжилт, гэрээний нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

ДӨРӨВ. ХОЛБООНЫ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1.Гадаадын жуулчдаас санал, хүсэлтийг нь хүлээн авч, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах талаар судалгааны ажлыг зохион байгуулна.

4.2.Аймгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд аялал жуулчлалын мэргэжлийн арга зүй, зөвлөгөөгөөр хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.3.Аймгийн зочлох үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж, жуулчдын сэтгэл ханамжийг өндөр байлгах, аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг хангаж буй эсэхэд хяналт тавьж, дэмжиж ажиллана.

4.4.Холбооны цахим хуудсанд хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээллийг байрлуулан, гадаад улсад энэ талаар сурталчлах, жуулчдын тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэн, холбооны гишүүн болон харилцагч байгууллагуудад уриалга хүргүүлнэ.

4.5.Хууль, тогтоомжийн хэрэгжилт, гэрээний нөхцөлийг хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавьж, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.


ТАВ. БУСАД

5.1.Талууд Санамж бичгийг хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээг тухай бүрд авч хэрэгжүүлнэ.

5.2.Энэхүү Санамж бичиг нь заавал биелэгдэх шинжтэй, эрх зүйн үр дагавар үүсгэж буй баримт бичиг биш бөгөөд Санамж бичгийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг энэхүү Санамж бичгийн үндсэн нөхцөлд нийцүүлэн, гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН:


БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Б.БАТ-ЭРДЭНЭ


БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
Б.АРИУН-ЭРДЭНЭ


АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН
ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
Ц.БААТАРСАЙХАН